



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.28 № 02/37 ЧАТ-САТ/2014/33/СЖИА-Л/ЕЗ

Зөрчил арилгуулах тухай

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад дараах зөрчил илэрлээ.

Төрийн өмчийн хорооны 2013 оны 555 дугаар тогтоолоор "Алтандорнод Монгол" ХХК-иас татварын өрөнд хураан авсан 54,860.8 сая төгрөгийн хөрөнгийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих санд шилжүүлэн авахаар тогтоож, Сангийн яамны 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 9-1/1454 дүгээр албан бичигт уг хөрөнгийг мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс авсан хөрөнгө оруулалтаар тайлагнахыг зөвлөжээ.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3-т "Татварын өрийг татвар төлөгчийн эд хөрөнгөөс гаргуулах бол энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу барьцааны гэрээ байгуулж, татвар төлөгчийн тодорхой эд хөрөнгийг барьцаалах буюу татвар төлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр тодорхой нөхцөл, болзолтойгоор нийтэд зарлан хуралдаж, үнийг төсвийн орлогод оруулж болно.", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ:**

Дээрх зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2014 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний Аудитын газарт хариу ирүүлэхийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт, Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Н.БАТСАЙХАН

20122